



МОНГОЛ УЛСЫН
АЖ ҮЙЛДВЭР, ЭРДЭС БАЯЛГИЙН
САЙДЫН ТУШААЛ

2024 оны 12 сарын 31 өдөр

Дугаар А/108

Улаанбаатар хот

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө
батлах тухай

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.4 дэх заалт, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн А/106 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2025 онд худалдан авах бараа, ажил, үйлчилгээний ерөнхий төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2. Батлагдсан төлөвлөгөөний дагуу худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулж, тайлагнахыг Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга (С.Жавхланбаатар), Ашигт малтмал, газрын тосны газрын дарга (Ш.Ганхуяг), Үндэсний геологийн албаны дарга (Б.Мөнхтөр), Цөмийн энергийн комиссын ажлын албаны дарга (Г.Манлайжав) нарт тус тус даалгасугай.

3. Батлагдсан төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Б.Өнөмөнх/-т үүрэг болгосугай.

САЙД



Ц.ТУВААН

1508 01 0008



Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын 2024 оны 12 дугаар сарын 31-ны өдрийн 103 дугаар тушаалын хавсралт 4

№	Төндөр шалгаруулалтын код	Худалдан авах бараа, ажил, үйлчилгээний санхүүжилтийн эх үүсвэр, нэр төрөл, тоо хэмжээ, хүчин чадал	Төрөл (бараа, ажил, зөвлөх үйлчилгээ, зөвлөхөөс бусад үйлчилгээ)	Төсөвт өртөг (мян.төг)	Тухайн онд санхүүжих дүн (мян.төг)	Худалдан авах ажиллагаанд мөрдөх журам, арга	Төндөр зарлах огноо	Тайлбар, тодруулга
IV.		Цөмийн энергийн комиссын ажлын алба						
1		Урсгал төсөв						
		Хангамж бараа материалын зардал						
1.1		Бичиг хэрэг	Бараа	2,500.0	2,500.0	ШХА	-	Тухай бүр худалдан авалт хийнэ.
1.2		Тээвэр шатахуун	Бараа	2,500.0	2,500.0	ШХА	-	Тухай бүр худалдан авалт хийнэ.
1.3		Бага үнэтэй түргэн элэгдэх ахуйн эд зүйлс	Бараа	8,950.6	8,950.6	ШХА	-	Тухай бүр худалдан авалт хийнэ.
		Дүн		13,950.6	13,950.6			
		Эд хогшил, урсгал засварын зардал						
1.4		Багаж, техник хэрэгсэл	Бараа	61,129.30	61,129.3	ХА	2025.03.25	Тухай бүр худалдан авалтыг хийнэ.
1.5		Хөдөлмөр хамгаалал	Бараа	4,551.7	4,551.7	ШХА	-	Тухай бүр худалдан авалтыг хийнэ.
1.6		Урсгал засвар	Ажил	45,000.0	45,000.0	ХА		
		Дүн		110,681.0	110,681.0			
		НИЙТ ДҮН		124,631.60	124,631.60			